

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024.12.10

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 45 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг жилийн эцсийн зорилtot түвшин, үр дүнтэй харьцуулан үнэлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримтлав.

Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Биеийн тамир, спортын улсын хорооны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явц 3 зорилгын хүрээнд 10 зорилт 45 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулж 30 арга хэмжээ “үр дүнтэй” буюу 100 хувь, 10 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хүртэл хувь, 5 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” 31 – 69 хүртэл хувьтай тус тус үнэлэгдэж зорилтын дундаж 92,9 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

№	Дэс дугаар	Арга хэмжээний	Үйцэтгэлийн хувь
<i>Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх (эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах) нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох.</i>			
Зорилт-1.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх.			85%
1.	1.1.1	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөний зөвлөмж боловсруулах, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.	100%
	1.1.2	Насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамирын арга хэмжээ, спортоор хичээллэх үйл ажиллагааг зохион байгуулах.	100%
	1.1.3	Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааг бүсээр зохион байгуулах.	80%
	1.1.4	Биеийн тамир, спортын чиглэлд төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, зардлыг санхүүжүүлж, ажлын байр бий болгох.	100%
	1.1.5	Цахим мэдээллийн санд үндэсний шигшээ багийн бус спортын холбоодын үйл ажиллагаатай холбоотой өгөгдөл, мэдээлэл байршуулах.	100%
	1.1.6	Үндэсний шигшээ багийн дэд системийн хөгжүүлэлтийн техникийн баримт бичиг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах.	30%
	1.1.7	Салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангаас e-mongolia системд төрийн цахим үйлчилгээг бий болгох.	100%
	1.1.8	Иргэдийн биеийн бялдрын түвшин тогтоох сорилын төвийг 2 аймаг, 2 дүүрэгт шинээр байгуулах (тоног төхөөрөмжөөр хангах), үйл ажиллагааг туршилтаар эхлүүлэх.	70%
Зорилт-1.2 Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барих.			94%
2.	1.2.1	Налайх, Дархан-Уул, иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолбор, Багахангай, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн спортын ордныг ашиглалтад оруулах.	90%
	1.2.2	Шинээр баригдах спортын 16 барилга байгууламжийн худалдан авах ажиллагааны үр дүнд төсвийн гүйцэтгэлээр санхүүжүүлэх.	92%
	1.2.3	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны шаардлага хангахгүй байгаа шалыг шинэчлэх ажлын даалгавар, шаардагдах төсвийн судалгааны төсөл боловсруулах.	100%
<i>Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх.</i>			
Зорилт-2.2 Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах.			98%
3.	2.2.1	Үндэсний шигшээ багийн холбоодтой байгуулсан улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих.	100%
	2.2.2	Олимпийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад сар бүр урамшуулал олгох.	100%
	2.2.3	Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад нэг удаагийн мөнгөн шагнал олгох.	100%
	2.2.4	Үндэсний шигшээ багуудыг “Парис-2024” олимп, паралимпийн наадамд бэлтгэн оролцуулах, “Милан Кортина-2026” ёвлийн олимп, паралимпийн наадамд оролцох эрх авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	84%
	2.2.5	Үндэсний хэмжээнд спортын наадам, тэмцээн, улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах.	100%
	2.2.6	Монгол Улсад зохион байгууллагдах олон улс, тив, дэлхийн тэмцээнд Засгийн газрын тогтоолын дагуу дэмжлэг үзүүлэх, хяналт тавин хамтран ажиллах.	100%

	2.2.7	Олимпын бус дэлхий, тивийн наадам, тэмцээнд дэмжлэг үзүүлэх.	100%
	2.2.8	Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ хийх болон өсвөр үеийн шигшээ багийн нэгдсэн бэлтгэл цугларалтыг зохион байгуулах улсын хэмжээнд.	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах			
Зорилт 3.1		Биеийн тамир, спортын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх	81,6%
4.	3.1.1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийх аргачлал батлуулах.	60%
	3.1.2	Орон нутгийн биеийн тамир, спортын төсвийн зардал тооцох аргачлал батлуулах.	50%
	3.1.3	Салбарын хөгжлийн түвшнийг тодорхойлох судалгааг хийлгэх судалгааны ажлын даалгавар боловсруулах, гүйцэтгэх олон улсын байгууллагатай санал солилцох.	90%
	3.1.4	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" 173 дугаар тогтоолд хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг мөнгөн шагналын хэмжээ, шалгуур үзүүлэлттэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах, тогтоолын төсөл боловсруулах.	100%
	3.1.5	"Биеийн тамир, спортын салбарын улсын 2 дугаар үзлэг тооллого"-ын удирдамж, зааврын дагуу зохион байгуулах.	90%
	3.1.6	ЮНЕСКО-ийн спорт дахь допинг хэрэглэхийг эсрэг конвенц, допингийн эсрэг үндэсний дурмийн хэрэгжилтийг хангуулах талаар Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах.	100%
	Зорилт-3.2	Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах.	100%
5.	3.2.1	Гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах.	100%
	3.2.2	Салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тайланг нэгтгэн тайлагнах.	100%
	3.2.3	Салбарын 100 жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хангах.	100%
	3.2.4	"Эрэг хандлага-Эрүүл нийгэм" аяны үзэл баримтлалыг салбарын үйл ажиллагааны баримтлан хэвшүүлэх.	100%
	3.2.5	Салбарын болон байгууллагын хэмжээнд байгуулагдсан орон тооны бус зөвлөл, дэд зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	100%
Зорилт-3.3		Биеийн тамир, спортын салбарын болон хорооны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.	100%
6.	3.3.1	Байгууллагын албан хаагчдын 2024 оны сургалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах.	100%
	3.3.2	Байгууллагын албан хаагчдын 2024 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах.	100%
Зорилт-3.4		Төвлөрүүлэн захирагчийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, зохицуулалтаар хангах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах.	95%
7.	3.4.1	Салбарын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах.	100%
	3.4.2	2024 оны батлагдсан төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардааар санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт хангах, гүйцэтгэл тайлагнах.	90%
Зорилт-3.5		Биеийн тамир, спортын салбар болон агентлагийн гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх.	76%
8.	3.5.1	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны комиссын ээлжит 25 дугаар хуралдааны төлөвлөгөөний хэрэгжилт хангах.	50%
	3.5.2	БНХАУ-ын Биеийн тамир, спортын улсын ерөнхий хороо, Бээжингийн Спортын Их Сургуультай хамтран салбарын албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах.	90%

	3.5.3	Япон улсын Шизуока мужийн Яйзү хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд салбарын албан хаагч, арга зүйч нарыг сургалтад хамруулах	50%
	3.5.4	Гадаад хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах.	90%
	3.5.5	“Парис-2024” олимп, паралимпийн наадамд оролцох албаны төлөөлөгчдийн айлчлал зохион байгуулах	100%
	Зорилт-3.6 Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих.	100%	
10.	3.6.1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд ХШҮ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах.	100%
	3.6.2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд ХШҮ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах.	100%
	3.6.3	Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд ХШҮ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах.	100%
	Зорилт-3.7 Биеийн тамир спортын салбарын хэмжээнд дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэн сайжруулах.	100%	
11.	3.7.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад эрсдэлд сууринсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах.	100%
	3.7.2	Хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, хамтран ажиллах.	100%
	3.7.3	“Дотоод аудитын 2024 оны төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг хангах.	100%
	Зорилтын дундаж хувь		92,9%

Дөрөв. Дүгнэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлтэд үнэлгээ өгөх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэх, гарсан алдаа, дутагдлыг арилгах, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэдэг билээ. Биеийн тамир, спортын улсын хорооны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн зорилтын дундаж 92,2 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байгаа нь 2024 оны эхний хагас жилийн хяналт-шинжилгээ үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан нь харагдаж байна. Төлөвлөгөөнд туссан зарим арга хэмжээний биелэлт Засгийн газрын бүтэц өөрчлөгдөж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд төсөв шилжсэнтэй холбоотой хэрэгжилт гаргах боломжгүй болсон байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 зорилгын хүрээнд 10 зорилт бүхий 45 арга хэмжээнээс 29 арга хэмжээ нь 100 хувь буюу “үр дүнтэй” хэрэгжсэн байна. Мөн оны эхний хагас жилийн үр дүнгүй байсан 8 арга хэмжээг тодорхой үр дүнд хүргэж ажилласан нь сайшаалтай байна.

Гэвч зарим арга хэмжээнд төлөвлөгөөг оновчтой тодорхойлоогүй, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг холбогдох журам, аргачлалын дагуу тодорхой, хэмжигдэхүйц байдлаар томьёолоогүй нь үнэлгээ буурах үндэслэл болж байна.

Зорилт-1.1-ийн хүрээнд туссан арга хэмжээ:

1.1.3. Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх арга хэмжээ нь хүрсэн түвшин тодорхойгүй, 2023 онтой харьцуулсан тоон үзүүлэлт хангалтгүй байна.

Өөрөөр хэлбэл тоон мэдээлэл нь чанарын үзүүлэлтээр баталгаажсан байх шаардлагыг хангаагүй байна. Тиймээс улсын хэмжээнд ажиллаж байгаа арга зүйчийн тоог 2023-2024 оны байдлаар аймаг, сум, дүүргийн хэмжээнд дэлгэрэнгүй гаргах шаардлагатай байна.

1.1.6. Үндэсний шигшээ багийн дэд системийн хөгжүүлэлтийн техникийн баримт бичиг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах арга хэмжээ нь төлөвлөгөөнөд заасан хугацаа дууссан хэрэгжилт хангалтгүй байна. Ажлын даалгаварыг боловсруулах ажлын хэсгийг дахин байгуулж арга хэмжээг үр дүнд хүргэн ажиллах шаардлагатай байна.

Тав. Зөвлөмж: Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Бүх албан хаагчдад:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа зөвлөмжийн биелэлтийг хангах, салбарын хэмжээнд хүрсэн үр дүнг зарцуулсан төсөвтэй уялдуулан нотлох баримттай тайлагнах,

2. Тухайн төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолох, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах, хэрэгжээгүй тохиолдолд шалтгаан нөхцлийг тодорхой тайлagnаж байх,

Газар, хэлтсийн удирдлагуудад:

1. Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх арга хэмжээг өмнөх оны тоон үзүүлэлтэд харьцуулан тайлагнахыг Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэст,

2. Үндэсний шигшээ багийн дэд системийн хөгжүүлэлтийн техникийн баримт бичиг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах арга хэмжээг анхаарч ажиллахыг Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтэст,

3. Хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх газар, хэлтэст,

4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 3.1-ийн 3.1.1, 3.1.2, зорилт 3.5-ын 3.5.1, 3.5.3-т заасан “эрчимжүүлэх шаардлагатай” арга хэмжээг холбогдох газар, хэлтсүүд анхааран ажиллаж, хэрэгжилтийг сайжруулах,

5. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, тухайн жилийн зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, суурь түшинг тооцоо судалгаанд үндэслэн бодитой тодорхой тусгасан шаардлага хангасан тайланг нэгтгэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны, удирдлагын газар болон бусад газар, хэлтэст тус тус зөвлөмж хүргүүлж байна.

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Аргачлал, загвар батлах тухай” тушаалтыг тус тус мөрдөж, төлөвлөлтийг сайжруулахад анхааран ажиллана уу. Та бүхэнд амжилт хүсье.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
ХШУДАХ-ИЙН ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.БАТСҮХ

Д.УРАНБИЛИГ